



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/29

Арвайхээр

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн
газрын бүтэц, орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 65.1.8, Засгийн газрын 2018 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн батлан тогтоох тухай” 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Захирамжийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хаагчдад танилцуулж, бүтэц, орон тооны дагуу зохион байгуулалт хийж, ажлын байрны тодорхойлолтыг батлан мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ж.Энх-Амар)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/64 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Сайнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100075